

ОРХОН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Бүсийн оношилгоо эмчилгээний төв

11дүгээр сарын 03

№	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	Төсөв /сая.төг/	Хөрөнгийн эх үүсвэр	Хүрсэн түвшин	Зарцулсан төсөв /сая.төг/	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжилтийн тайлбар
						Он	Түвшин							
ОРХОН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ: ЭРҮҮЛ, БҮТЭЭЛЧ, ХӨГЖИХ ТЭМҮҮЛЭЛТЭЙ-ЭРДЭНЭТ ХҮН БҮЛГИЙН ХҮРЭЭНД САЛБАРЫН ҮР ДҮН 2: ЭРҮҮЛ, ОЮУНЛАГ, ИРГЭНИЙГ БҮТЭЭНЭ														
1.	2.1. Халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна.	2.1.1.Амьдралын зөв дадал хэвшилтэй иргэдийн тоог нэмэгдүүлнэ.	2.1.1.2.“Иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг оношилгоонд хамрагдах нөхцөлийг сайжруулах	Үзлэгт хамрагдсан иргэд	Хувь	2023	34	36	20.0	ОНТ	35	-	97.2	Тайлант хугацаанд урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт 1963 иргэн хамрагдсанаас давхардсан тоогоор өвчлөлийн 4620 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс 1434 буюу 31% нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин, 1293 буюу 28% нь дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, 495 буюу 10.7% нь шээс бэлгийн тогтолцооны өвчин, 1012 буюу 21.9% нь зүрх судасны тогтолцооны өвчин, 78 буюу 1.7% нь амьсгалын тогтолцооны өвчлөлүүд байна. Хавдрын 6 тохиолдол илэрсэн ба ходоодны хавдар 4 (C16), элэгний хавдар 1 (C22.0), Уушгины хавдар 1 (34.0) байв. Ходоодны эрт үеийн хавдартай 1 тохиолдолд ходоодны салст хуулах мэс заслыг амжилттай хийсэн. Уушигны хавдартай 1 тохиолдол орон нутагтаа хими эмчилгээнд хамрагдаж байна. Бусад тохиолдлыг ХСҮТ-д илгээсэн. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг насны хувьд 18-30 нас 210, 31-45 нас 638, 46-60 нас 671, 61-с дээш 444 байна.
2.														
3.			2.1.1.3.“Заавал хийх товллын дархлаажуулалтад хүүхэд бүрийг бүрэн хамруулах, тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалтыг зохион байгуулж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, тарилгатай											

			халдварт өвчний бүртгэл, мэдээлэл, тандалтыг эрчимжүүлэх											
4.			2.2.1.2. Сэргийлж болох нас баралт, осол гэмтлийн нас баралтыг бууруулахаар эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй амилуулах суурь тусламжийн чадавхыг нэмэгдүүлэх	Амь тэнссэн тусламж үйлчилгээн ий чадавх	Хувь	2023	91	91.5	10.0	ОНТ	91.8	-	100	Тайлант хугацаанд осол гэмтлийн өвчлөлийн 625 тохиолдол бүртгэгдэж, 10.000 хүн амд 59. байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.9-өөр өссөн ба зам тээврийн ослын 161 тохиолдол буюу 25.7 % бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.7 %-аар буурсан байна. Осол гэмтлийн дуудлага 845, амбулаторийн үзлэг 8449. Нас баралт 14, үүнээс архины хордлого 10, зам тээврийн осол 4 бүртгэгдсэн байна. БОЭТ-ийн эмч мэргэжилтнүүдийн амь тэнссэн үеийн лавшруулсан тусламж үйлчилгээ үзүүлэх ур чадварыг бэхжүүлэх зорилгоор ажил мэргэжлийн тэмцээнийг 2үе шаттай зохион байгуулж давхардсан тоогоор 23тасгийн 105 эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан. Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран аймгийн ЭМБ-ын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Амилуулах суурь тусламж үзүүлэх” сургалтыг зохион байгуулж БОЭТ-өөс 178 эмч, сувилагч оролцсон. Байгууллагын ажлын байрны сургалтын хөтөлбөрт амь тэнссэн үед тусламж үйлчилгээ үзүүлэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тасаг нэгжүүдийн хамтын ажиллагаа бэлэн байдлыг хангах чиглэлээр 4удаагийн сургалт төлөвлөгдсөн бөгөөд давхардсан тоогоор 305 эмч, сувилагч, жолооч нар хамрагдсан.
5.			2.2.1.3. БОЭТ-ийн Амбулаторийн өргөтгөлийн барилгатай болгож ажиллах орчин нөхцөлийг сайжруулах	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	2023	-	100	638.3	ОНТ	-	-	0	Амбулаторийн өргөтгөлийн зураг төсвийг орон нутгийн хөрөнгө зөвлөх үйлчилгээгээр Вилла Проект ХХК хийж “Хот, Байгуулалт Барилга Захилаг”ч албад хүлээлгэж өгсөн. Ирэх оны төсвийн саналд оруулах асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.
6.	2.3. Эрүүл мэндийн байгууллаг ын чадавхыг нэмэгдүүлн э.	2.3.1.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах,	2.3.1.1. Эм зүйн салбарын ил тод хариуцлагатай байдлыг бэхжүүлж, стандартын хэрэгжилтийг хангуулан	Эм ханган нийлүүлэх байгууллага , эмийн сангуудын стандартын хэрэгжилт	Хувь	2023	95.1	95.2	-	-	95.7	-	100	БОЭТ-ийн Эмзүйн тасаг нь MNS 5260:2015 стандартыг мөрдөж ажилладаг бөгөөд стандартын хэрэгжилт 85%. Тайлант хугацаанд бүх тасаг нэгжүүдэд ЭМС-ын 2015 оны А/68, 2009 оны А/388 тушаалын хэрэгжилт, MNS 5260:2015 стандартыг тус тус үндэслэн дотоод хяналт хийхэд дунджаар 78% үнэлэгдэж

		хангамж хүртээмжийг нэмэгдүүлнэ	тогтвортой үйл ажиллагааг дэмжих 2.3.1.3. Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавх, гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийг нэмэгдүүлэх	Хариу арга хэмжээний чадавх, ЭМБ-ын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт	Хувь	2023	95	95.2	30.0	ОНТ	70	186.0	73.5	зөвлөмж хүргүүлж ажилласан ба эргэн хяналтаар зөвлөмжийн хэрэгжилт 87,4% .
7.														Байгууллагын захирлын 2025 оны А/56 дугаар тушаалаар “Шуурхай удирдлагын баг”, А/57 дугаар тушаалаар “Эрсдэлийн үнэлгээний баг” тус тус шинэчлэн томилогдож гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Үүнд: 1. Улаанбурхан өвчний нөхцөл байдалд хийгдсэн эрсдэлийн үнэлгээ Өндөр эрсдэлтэй буюу улбар шар түвшинд үнэлэгдсэн ба хариу арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлж нийт 75 үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчилсэн. Нас баралт, хүндрэл бүртгэгдээгүй. 2. Хоолны хордлогын 277 тохиолдлыг хүлээн авч нэмэлтээр 150 ор дэлгэн эмнэлгийн тусламж үйлчилгээг эрчимжүүлж ажилласан. Нас баралт, хүндрэл бүртгэгдээгүй. 3. Томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж ажлын хэсгийн хуралд 2 удаа хуралдан 6 асуудал хэлэлцэж, шийдвэрийн хэрэгжилтийг 86.4% ханган ажиллаж байна. Нөөцийн хувьд түргэвчилсэн оношлуур 400, вирусын эсрэг эм тамифлю 75мг-2000таб, 45мг-50таб,30мг-500таб байна.
8.			2.3.1.4. БОЭТ-ийн оношилгоо, эмчилгээний чадавхыг нэмэгдүүлэх, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх	Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	Хувь	2023	95	95.5	1,100.0	УТ, Гадаад Зээл Тусламж	96	4,800.0	100	Иргэдийн орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгын хүрээнд “Үндэсний баг”-тай хамтран нийт 810 эмчийн үзлэг, хавдрын мэс засал 23, судсан дотуурх оношилгоо, эмчилгээ 131, ажилбар 17, хими эмчилгээ 49 хийсэн.Үүнд: Элэг тайрах мэс засал 7, ходоод тайрах мэс засал 2, хөхний хавдрын мэс засал 3, ТАСЕ 11. БОЭТ-ийн эмч нар бие дааж элэг тайрах мэс засал 1, ТАСЕ 10, доод мөчдийн их өнгөц венийн судасыг сугалж авах мэс заслын 7 тохиолдлыг амжилттай хийсэн. Мөн үндэсний багтай хамтарч тархины судасны 14оношилгоо хийж аневризм 6, гүрээний судасны бөглөрөл ба нарийслын 1 тохиолдол шинээр оношлогдсон ба орон нутагт хийгдэггүй зарим мэс заслыг нэвтрүүлж нутагшуулах зорилгоор ШУГТЭ, УХТЭ-т хүсэлт хүргүүлэн хамтын ажиллагааны хүрээнд гүрээний судасны бөглөрөл, нарийсалд

													стент тавих 1, судсан дотуур аневризм засах 1 мэс заслыг бие даан амжилттай хийсэн. Оношилгооны чадавхийг сайжруулах, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 2025 онд 3,392,060,445 төгрөгний үнэ бүхий 144ш тоног төхөөрөмжөөр хангагдсан ба өмнөх онтой харьцуулахад 0.5 хувиар нэмэгдсэн буюу 96%ийн хангалттай байна.
Хэрэгжилт – 80.4%													

ХЯНАЛТ –ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

А.БАЯРХҮҮ

ТАНИЛЦСАН:

БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАН-ЭРДЭНЭ